



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 06 өдөр

Дугаар 7/43

Хужирт сум

Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай  
тэмцэх ажлыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Ургамал хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2023 оны “Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах тухай” А175 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч тархсан 1,2,3,4,5,6 дугаар багийн 4400 га бэлчээрт микробиологийн аргаар тэмцэх ажлыг 2023 оны 04 дүгээр сарын 12-13-ны өдрийн хооронд зохион байгуулсугай.
2. Бэлчээрийн хөнөөлт мэрэгч амьтантай тэмцэх ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр, хяналт тавьж, үр дүнг тооцох ажлын хэсгийг хоёрдугаар хавсралтаар тус тус байгуулсугай.
3. Мэрэгчтэй тэмцэх ажилд малчид, малчны бүлэг, хоршооны гишүүдийг хамруулах, тэднийг мэрэгч устгалын гарын авлага, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлэх, богино хугацаанд бэлтгэл зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч Б.Дэмбэрэлд үүрэг болгосугай.
4. Мэрэгчтэй тэмцэх ажлын явц, үр дүн, чанарт хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны хяналтын Улсын байцаагч Б.Бямбасүрэн, ажлын гүйцэтгэлийн тайлан мэдээг заавар журмын дагуу гаргаж 2023 оны 05 дугаар сарын 01-ний дотор аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга Д.Мөнхбат нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ